# Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын талаарх уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн судалгаа

*А.Батжаргал[1], Б.Халиун[1], Р.Наранхүү[1], Б.Цэрэнцоо[2], Д.Цэрэндагва[3]*

*[1]АШУҮИС, МАУОУС*
*[2]АШУҮИС, МАУОУС, Жор судлалын тэнхим*
*[3]АШУҮИС, МАУОУС, Дотор өвчин судлалын тэнхим*
*Цахим хаяг: jargal0821@gmail.com, Утас: 94770821*

**Түлхүүр үг:**

Pulsatilla Bungeana L.,
Ходоодны хавдар
Өвсөн гурван халуун

**Товч утга**

**Үндэслэл:** Ходоодны хорт хавдар нь дэлхий дахинд хийгээд манай улсын хэмжээнд маш өндөр тархалттайгаас гадна нас баралт ихтэй аюулт өвчин юм[4]. Дэлхий нийтээр энэхүү өвчнийг эмчлэх Дорно дахины (уламжлалт) анагаах ухааны аргыг тал бүрээс нь сонирхон судалж, байгаль дээрх эмт ургамлуудаас бүтсэн гаж нөлөө багатай шинэ эм, бэлдмэлүүдийг гарган авч, практикт нэвтрүүлэх хандлага маш хурдацтай өсөн нэмэгдсээр байна[1]. **Зорилго:** “Өвсөн гурван халуун” жор, түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлыг уламжлалт анагаах ухааны сурвалжууд болон тэдгээрийн түгээмэл хэрэглэгддэг тайлбар зохиолуудад хэрхэн дурдсан талаар харьцуулан шинжлэн, нэгтгэн дүгнэх. **Арга, аргачлал:** “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” “Нандин эрдэнийн шимийн хураангуй”, “Хөх бидэр”, “Үзэгсдийн баясгалан”, “Монгол тан эмийн танилцуулга”, “Маш гайхамшигт хуримын сан”, “Эм таних ухаан”, “Монгол эмийг зөв таних толь” бүтээлүүдийг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”-аар харьцуулан, “Нэгтгэн дүгнэх арга”- аар хураангуйлан үнэлэв. **Үр дүн:** “Нандин эрдэнийн шимийн хураангуй” зохиолын эмийн хураангуй товч нэрийн хэсэгт: “Өвсөн гурван халуун” жорд Жэцасэрво (Төвөд нэр) буюу мөлхөө холтсон цэцэг, Юмонгарво (Төвөд нэр) буюу чөдөр өвс, Срүвга (Төвөд нэр) буюу Бунгийн яргуй орно гэж бичжээ. “Монгол тан эмийн танилцуулга” номд: Срүвга (Төвөд нэр) нь гошуун, гашуун, бүлээн амт чанартай, цул сав бүхэнд гүйнэ. “Эм таних ухаан” бүтээлд: Эмийн эрхэм болсон буган цагаан цэцгийг Төвөд хэлээр Срүвга гэнэ хэмээгээд ургамлын гадаад байдлыг сайтар тусган бичсэн байна. **Дүгнэлт:** 1. “Өвсөн гурван халуун” жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын Дорно дахины анагаах ухааны олон зуунд дамжуулан баримталж ирсэн эмчилгээнд хэрэглэх арга, өвчний заалтын талаар харьцуулан судлахад сурвалж тус бүрт төстэй байдлаар тэмдэглэгдсэн байна. 2. “Өвсөн гурван халуун” жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын амт чадлын талаар цөөн зохиолуудад дурдсан ба тус ургамлын бадганыг дарах хөнгөн, ширүүн, хурц, халуун чадал нь илүү болох нь харагдаж байна.

**Үндэслэл:** Уламжлалт анагаах ухааны онолоор бие махбодод өвчний ямар нэгэн үүсгэвэр бүхий өвчнүүд бол хамт төрсөн найман яр өвчний үр өвчин болон их архаг бэтэг өвчнүүд юм. Мөн язгуурын бадган өвчний ангилалд багтах төмөр хагт бадган болон хоолой хаагдах бадган, уяман зэрэг өвчнүүд нь үр өвчинд зүй ёсоор хамаарах бөгөөд үр өвчин гэдэг ойлголтод хортой хавдрыг хамааруулан авч үзэж болох ажээ[1].

Мөн эдгээр өвчнүүдийн үед “Өвсөн гурван халуун” жор, түүнд агуулагдах Бунгийн яргуй-г Срүвга (Төвөд нэр) (*Pulsatilla Bungeana L.*), Мөлхөө холтсон цэцэг-г Жэцасэрво (Төвөд нэр) (*Ranunculus repens L.*), Чөдөр өвс-г Юмонгарво (Төвөд нэр) (*Atragene sibirica L.*) гэх ба дээрх ургамлуудыг эрт дээр үеэс монгол эмийн эмчилгээнд хэрэглэсээр ирсэн байна[2].

Дэлхийн нийтэд хамгийн өндөр тархалттай хорт хавдруудыг жагсаавал ходоодны хорт хавдар нь 5-р байранд, харин үхлийн аюул өндөртэй хавдруудаас ходоодны хорт хавдар нь 3-р байранд жагсаж, бүх хавдрын 5,7%-ийг эзэлж байна. 2018 оны байдлаар ходоодны хорт хавдрын 1,033,701 шинэ тохиолдол, 783,000 нас баралт бүртгэгджээ[3].

Харин Монгол улс нь ходоодны хорт хавдрын өвчлөлөөрөө дэлхий дахинд 2-р байранд жагссан үзүүлэлттэй байнащ.

Иймээс энэ өвчнийг эмчлэх боломж бүхий Дорно дахины (уламжлалт) анагаах ухаанд эрт үеэс хэрэглэж ирсэн энэхүү эмийн ургамлын үйлдлийг орчин үеийн анагаах ухааны судалгааны аргаар нотолгоожуулах нь нэн тэргүүний асуудал юм.

**Зорилго:** “Өвсөн гурван халуун” жор, түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлыг уламжлалт анагаах ухааны сурвалжууд болон түгээмэл хэрэглэгддэг тайлбар зохиолуудад хэрхэн дурдсан талаар харьцуулан шинжлэн, нэгтгэн дүгнэх

**Зорилт:**

1. “Өвсөн гурван халуун” жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын амт, чадал, хэрэглэх арга, өвчний заалтын талаар сурвалж зохиолуудад дурдагдсан мэдээллүүдийг харьцуулан шинжлэх
2. “Өвсөн гурван халуун” жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын амт, чадал, хэрэглэх арга, өвчний заалтын талаар сурвалж зохиолуудад дурдагдсан мэдээллүүдийг нэгтгэн, дүгнэх

**Арга, аргачлал:** “АУДУ” “Нандин эрдэнийн шимийн хураангуй”, “Хөх бидэр”, “Үзэгсдийн баясгалан”, “Монгол тан эмийн танилцуулга”, “Маш гайхамшигт хуримын сан” “Эм таних ухаан”, “Монгол эмийг зөв таних толь” бүтээлүүдийг эх хэрэглэгдэхүүн болгож “Эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга”-аар[5] харьцуулан, “Нэгтгэн дүгнэх арга”- аар6 хураангуйлан үнэлэв.

**Үр дүн:** “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн бадган өвчнийг анагаах бүлэгт: галын илч буурсан бадган ба шингээн хатаагч бадганыг засах найрлагад Юмонгарво буюу Чөдөр өвс-г оруулсан байдаг бөгөөд хоолой хаагдах бадганыг засах найрлагад Срүвга буюу Бунгийн яргуй, Жэцасэрво буюу Мөлхөө холтсон цэцэг-г оруулж хэрэглэх тухай заасан байна[2].

“Нандин эрдэнийн шимийн хураангуй” зохиолын эмийн хураангуй товч нэрийн хэсэгт: “Өвсөн гурван халуун” жорд Жэцасэрво буюу Мөлхөө холтсон цэцэг, Юмонгарво буюу Чөдөр өвс, Срүвга буюу Бунгийн яргуй орно гэж бичжээ[7].

“Хөх бидэр”-т: Төмөр хагт бадганыг засахад жоншны үнсэн эмийг найруулж өг эсвэл Хойд үндэсний жоншны зөөлөн эмийн дээр бух гөрөөсний эвэр, “Өвсөн гурван халуун” болох Юмон, Жэца, Срүвга ба хар шудаг шингүн нугуудыг нэмж араатны мах шөл, архиар багсарч найруулсан хурц үнсэн эмийг өгч ховхолсугай гэж тэмдэглэсэн байна[8].

“Үзэгсдийн баясгалан” зохиолд: Жэца, Юмон, Срүвга гурав бол илчийг үүсгэж, шар усыг татах ба ялзрахыг зогсооно гэж бичжээ[9].

“Монгол тан эмийн танилцуулга” номд: Срүвга нь гошуун, гашуун. бүлээн амт чанартай, цул сав бүхэнд гүйнэ. Хийж дарж бадганыг арилгаж, судлыг нэвтрүүлж, эвэршээлийг зогсоох зэрэг чадал эрдэмтэй. Голдуу засах нь тал бие минчүүрэх, үе гишүүний шар усны өвчин, судал шөрмөс татах, гар хөл хөших, эл зүйлийн шалтгаанаас болсон шарх, ямаар толгой өвдөх зэргийг засна гэжээ[10].

“Маш гайхамшигт хуримын сан” зохиолд Талва ава-гийн найрлагад Жэца, Юмон, Срүвга-ийн үнс ордог ба халуун хүйтэн бэтэгний зүйл бүгдэд сайн гэж бичсэн байна[11].

“Эм таних ухаан” бүтээлд: Эмийн эрхэм болсон цорыг Төвөд хэлээр Срүвга гэнэ. Тойрог төлөвтэй навч нь нярай зөөлөвтөр, иш нь дөрвөн тийш намайлан салаалж, цагаан цэнхэр цэцгийн өнгө нь хурц биш бөгөөд хөх өнгөтэй жимс нь гох дэгээтэй байдаг. Гашуун, гошуун амттай өөрийн чадлаараа хүйтэн бэтгийг арилгана. Мөн тус номын нэмэлт тайлбарт: Срүвга бол хавар эрт цэцэглэж, зун болоход хувхайрдаг нэг зүйл бөгөөд холтсон цэцгийн язгуурын олон наст өвслөг ургамал болох Эгэл яргуй цэцэг (*Pulsatilla chinensis Bunge regel*)-ийн хатаасан цэцэг буюу бүхэл өвс юм гэжээ[12].

“Монгол эмийг зөв таних толь” бүтээлд: Срүвга нь найгалзсан иштэй, ишний хагасаас нь дөрвөн зүгт салаалж, үе бүрээс нь гурав, гурав сална. Гурван үзүүр шиг сэтэрхийтэй ногоон навчтай, таван хэлтэстэй цагаан цэцэгтэй, маш гошуун амттай, Дээдсийн сургаалд: Үр нь гох адил гэжээ. Энэ ба дээрх Юмон, Жэцатай нийлүүлэн өвсний гурван халуун гэдэг хэмээсэн байна[13].

**Хэлцэмж:** Бидний судалгаанд авч үзсэн сурвалжуудаас “Эм таних ухаан” бүтээлд дээрх “Өвсөн гурван халуун” жорд агуулагдах гурван ургамал, ялангуяа Срүвга-г таних арга, ургах орчин, амт, эрдэм чадлыг илүү тодорхой бичсэн төдийгүй ургамал зүйн ангиллыг нэмэлтээр тайлбарлаж оруулсан бол “Монгол эмийг зөв таних толь” бүтээлд Срүвга-г таних арга, амт эрдмийн талаар мөн бичсэн байна. Харин “Анагаах ухааны дөрвөн үндэс” тэргүүтэй бусад эх сурвалжуудад “Өвсөн гурван халуун”-ы хэрэглээ болон өвчний заалтыг тэмдэглэн үлдээсэн байна. Сурвалж зохиолуудыг судлахад холтсон цэцэгтний овгийн Бунгийн яргуй бол Срүвга, Сибирь чөдөр өвс бол Юмонгарво, Мөлхөө холтсон цэцэг нь Жэцасэрво гэх нэрээр эмд хэрэглэгдэж ирсэн нь харагдаж байна. Холтсон цэцэгтний овгийн дээрх гурван ургамал нь өвчний заалтын хувьд ижил төстэй байгаа нь онцлог

ба Бунгийн яргуйд бадганыг дарах хөнгөн, ширүүн, хурц, халуун чадал илүүтэй агуулагджээ. Иймээс бадганыг арилгаж, судлыг нэвтрүүлэх, эвэршээлийг зогсоох, хорхойг нядлах, илчийг үүсгэж бэтгийг эвдэх, илжрэхийг зогсоож шар усыг татах, усан хаванг хатаах эрдмээрээ, мөн бадган тэргүүтэй эс шингэсэн, төмөр хагт бадган, хоолой хаагдах бадган, ходоодны хүйтэн бэтэг, сахуугийн зүйлийг анагаах жор найрлагад оруулж хэрэглэж ирсэн гэж дурджээ.

Судлаач Р. Наранхүү "Ходоодны хорт хавдрын (AGS) эсэд "Өвсөн гурван халуун"-ы үзүүлэх нөлөө" (2018) сэдэвт магистрын зэрэг горилсон судалгаандаа Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*)-н 70% этанолон ханд нь хяналтын бүлэгтэй харьцуулахад ($p<0.01$) тун хамааралтайгаар ходоодны хавдрын (AGS) эсийн ургалтыг саатуулж, хавдрын эсийн шилжин хөдлөх чадварын хурдыг бууруулах идэвхтэй болохыг тэмдэглэсэн байна. Мөн Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) нь хорт хавдрын эсрэг үйлдэл бүхий сапонин, апигенин, рутин, кверцетин зэрэг флавоноидууд түлхүү агуулдаг болохыг тэмдэглэжээ. Бид орчин үеийн анагаах ухааны судалгааны аргаар нотолгоожсон дээрх үр дүнгүүдэд тулгуурлан уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудад Бунгийн яргуй ургамлын үйлдлийн талаар хэрхэн дурдсаныг харьцуулан судлахад сурвалж тус бүрт төстэй байдлаар тэмдэглэгдсэн байна.

**Дүгнэлт:**

1. "Өвсөн гурван халуун" жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын уламжлалт анагаах ухааны олон зуунд дамжуулан баримталж ирсэн эмчилгээнд хэрэглэх арга, өвчний заалтын талаар харьцуулан судлахад сурвалж тус бүрт төстэй байдлаар тэмдэглэгдсэн байна.
2. "Өвсөн гурван халуун" жор, болон түүнд агуулагдах Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana L.*) ургамлын амт чадлын талаар цөөн зохиолуудад дурдсан ба тус ургамлын бадганыг дарах хөнгөн, ширүүн, хурц, халуун чадал нь илүү болох нь харагдаж байна.

**Ном зүй:**


1. *Сээсрэгдорж С, Чимэдрагчаа Ч, Хишигжаргал С. Монголын Дорно дахины анагаах ухааны өвчнийг анагаах увдис. Улаанбаатар. 2005. х.101,106,141, 264.*
2. *Анагаах ухааны дөрвөн үндэс (Хөрвүүлсэн Х.Тумбаа) УБ.1991. х.152-154*
3. *WHO. International Agency for Research on cancer. Cancer today. 2019*
4. *Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв. Эрүүл мэндийн үзүүлэлт 2018. УБ 2018. х.85-87.*
5. *Болд Ш. Монголын Дорно дахины ангаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.УБ. 2005. х.26*
6. *Жамьянгарав Д. "Лувсанданзанжанцаны анагаах ухааны талаар туурвисан зарим ховор зохиолуудын харьцуулсан судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, 2010. х.30.*
7. *Нандин эрдэнийн шимийн хураангуй. (Хөрвүүлсэн З.Мэндсайхан). УБ. 1993.*
8. *Дэсрид Санжаажамц. Хөх бидэр. Дунд дэвтэр. ӨМААХороо 1984. х.36*
9. *Жигмэдданзанжамц. Үзэгсдийн баясгалан. ӨМААХороо.1996. х.10-11*
10. *Монгол тан эмийн танилцуулга. УБ. 2008.*
11. *Чойжамц. Маш гайхамшигт хуримын сан. Хэвлэлд бэлтгэсэн З.Мэндсайхан. УБ.1991. х.123*
12. *Цахар гэвш Лувсанчүлтэм. Эм таних ухаан. ӨМААХороо.1998. х.82-90*
13. *Монгол эмийг зөв таних толь. Жамбалдорж. ӨМААХороо.1998.*

# A Traditional medical sources study on Bungiin yargui (*Pulsatilla Bungeana L.*)

*Batjargal A[1], Khaliun B[1], Narankhuu R[1], Tserentsoo B[2], Tserendagwa D[3]*

*[1]MNUMS, International School of Mongolian Medicine*
*[2]MNUMS, International School of Mongolian Medicine, Department of Traditional Prescriptionology*
*[3]MNUMS, International School of Mongolian Medicine, Department of Internal Medicine*
*Email: jargal0821@gmail.com, Tel: 94770821*

**Introduction:** Gastric cancer is a highly prevalent and deadly disease worldwide and in our country. There is a growing trend around the world to study Oriental (traditional) medicine to treat the disease, to develop new drugs with less side effects, and to put them into practice.
**Objective:** To analyze and summarize the "Hot natured three herbs" recipe and how the *Pulsatilla Bungeana L*. is mentioned in traditional medical sources and their commonly used commentaries.
**Methods:** "Four medical tantras", "Nandin erdeniin shimiin khuraangui", "Bider onbo", "Tonvagajod", "Introduction of Mongolian herbal medicine", "Mash gaikhamshigt khurimiin san", "Recognition of herbal medicine", "Dictionary of Mongolian herbal medicine recognition" as source materials. It was compared by the "Comparison Methodology of Source and Source Studies" and summarized by the "Summary Method".
**Results:** In the abstract names of drug section of the "Nandin erdeniin shimiin khuraangui": The recipe for "Hot natured three herbs", it includes jetsaservo (*Ranunculus repens L.*), yumongarvo (*Atragene sibirica L*), sruvga (*Bungiin yargui-Pulsatilla Bungeana L.*). In the "Introduction of Mongolian herbal medicine": sruvga is hot, bitter, has a warm taste and power, and it runs in every organs. In the "Recognition of herbal medicine": The deer white flower, which is considered to be a medicine, is called sruva in Tibetan, and the appearance of the plant is well documented.
**Conclusions:**

1. A comparative study of the "Hot natured Three herbs" recipe and the Bungiin yargui (*Pulsatilla Bungeana L.*) herb used in traditional medicine for centuries, and the indications for the disease, is noted in a similar way in each source.
2. The above recipe and the taste of the plant have been mentioned in a few resources, and the light, harsh, sharp, and hot power of the this plant has been shown to be superior.

**Keywords:** Pulsatilla Bungeana L., gastric cancer, Hot natured three herbs